



Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

**Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч,
мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт**



Төрийн цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна

Улаанбаатар хот 2006 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын хоёрдугаар газар

Захирал

О.Мэндбаяр

Аудитын менежер

М.Давааням

Ахлах аудитор

Г.Нямдорж

Аудитор

Ц.Сугармаа

Аудитор

З.Цээнээ

2006 оны 11 дүгээр сар

Тайланг ҮАГ-ын вэб
сайтаас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах асууж лавлах
зүйл байвал 261740 дугаарын
утас, 323266 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ. Үндэсний аудитын
газар. Засгийн газрын 4
дүгээр байр. Бага тойруу-6
Улаанбаатар-46
Монгол Улс

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	3
Аудитын стандартын талаархи мэдэгдэл.....	3

Бүлэг 1

Ажиллах хүч гадаадад гаргаж буй байдал.....	4
Зөвлөмж.....	8

Бүлэг 2

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч буй байдал.....	9
Зөвлөмж.....	11

Бүлэг 3

Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг хэрэгжүүлж буй байдал.....	12
Зөвлөмж.....	18

Бүлэг 4

НХХЯ, гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газар ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан байдал.....	19
Зөвлөмж.....	21

Холбогдох байгууллагын санал22

Хавсралт.....27

Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн
нэгтгэл.....28

Товчилсон үгс

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НХХ-ийн	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн
ҮХ-ны	Үйлдвэр худалдааны
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ХЭГ	Хөдөлмөр эрхлэлтийн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ГИХАЭА	Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх алба
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТББ	Төрийн бус байгууллага
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
АБТ	Ажлын байрны төлбөр

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ

УИХ-ын Дэд бүтцийн Байнгын хорооны (хуучин нэрээр) санал, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу НХХЯ, ХХҮГ, гадаадад ажиллах хүч гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын 2004-2005 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлийн аудит хийлээ.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- Ажиллах хүч гадаадад гаргаж буй байдал
- Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч буй байдал
- Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг хэрэгжүүлж буй байдал
- НХХЯ, гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газар ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан байдал

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
- Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох тухай ЗГ-ын тогтоолууд
- Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам, бусад холбогдох хууль тогтоомжууд

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитын явцад асуудлыг шинжлэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар мэдээ гаргуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан ҮАГ-2/2006/07-ГА төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

1. Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгож байгаа байдал

1.1 НХХ-ийн сайдын 2002 оны 113 дугаар тушаалаар батлагдсан “ХЭГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т тус газрыг “Гадаадад ажиллах иргэдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зөвлөгөө өгөх, гадаадад ажиллах хүч гаргах боломжийг судлах, гадаадын байгууллага иргэдтэй холбоо тогтоох” үйл ажиллагааны зорилттой ажиллахаар заажээ.

1.2 “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” УИХ-ын 2004 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор ХЭГ-ыг ХХҮГ болгон өөрчлөн зохион байгуулж, НХХ-ийн сайдын 2004 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “ХХҮГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т гадаадад ажиллах хүч гаргах асуудалтай холбогдсон стратеги болон үйл ажиллагааны зорилтууд тус газрын эрхлэх ажлын хүрээнээс хасагдаж энэ зорилтуудыг НХХЯ хэрэгжүүлэхээр болсон байна.

1.3 Гадаадын төрийн болон ТББ-тай гэрээ байгуулах, ажиллах хүч гадаадад гаргах талаар зуучлах тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, хугацааг нь сунгах, хүчингүй болгох, гадаадад гэрээгээр ажиллагчийн гэрээнд заасан үүргийн биелэлтэд хяналт тавьж, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг ХХҮГ хариуцахгүй болгосон дээрх шийдвэр нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.4 НХХЯ-ны гадаадад ажиллах хүч, дадлагажигч гаргах асуудлыг хариуцсан ажилтан гадаадад ажиллах хүч гаргахад зуучлагч компаниудад зөвшөөрөл олгох төдийгөөр ажлаа хязгаарлаж, ажиллах хүч гадаадад гаргах асуудлаар бодлого тодорхойлж хэрэгжилтийг хангуулах, төрийн болон ТББ-ын үйл ажиллагааг уялдуулах, илгээгч байгууллага иргэдтэй хэрхэн ажиллаж байгаад хяналт тавьж чадахгүй байна. Зүй нь НХХЯ бодлого тодорхойлж, агентлаг түүнийг нь хэрэгжүүлэх учиртай.

1.5 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу НХХЯ-наас Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг төрийн өмчийн оролцоотой нэг, хувийн өмчийн 20 аж ахуйн нэгж, байгууллагад олгожээ. /жагсаалтыг хавсаргав/


1.6 Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрөл авахдаа, гадаадын байгууллагатай байгуулсан гэрээ, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд зохих ёсоор хамрагдсан гэрчилгээ, тухайн байгууллага хэвийн ажиллах боломжтой тухай татварын албаны тодорхойлолт зэрэг 7 зүйлийн

баримт бичгийг бүрдүүлэхээр заасны дагуу аудитад хамрагдсан 14 компани хүлээн авагч байгууллагатай гэрээ байгуулж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлж, зөвшөөрлөө авсан байна.

1.7 Япон улсад ажиллах хүч илгээхэд зуучлах тусгай зөвшөөрөл авахаар 2005 онд “Ти Вай Эй” ХХК-иас ирүүлсэн хүсэлт, 2006 онд “Сита” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг холбогдох судалгаа хийсний эцэст шийдвэрлэхээр тогтжээ.

1.8 Зуучлах зөвшөөрөл авсан компаниуд БНСУ, Япон, БНЧУ, БНУУ, Тайваньд ажиллах хүч, дадлагажигчаар 2004 онд 2631 хүн, 2005 онд 5447 хүн гаргасан байна.

Зуучлагч компаниудын гадаадад ажиллах хүч, дадлагажигч зуучилсан байдал:



“Зуучлагч товчоо” ХХК байгуулагдсан эрх зүйн үндэслэл

1.9 Хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйл ажиллагаанд зонхилох байр суурийг эзэлдэг “Гадаадад ажиллах хүч зуучлан гаргах товчоо” төрийн өмчит ХХК-г НХХ-ийн сайдын 2002 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 127 дугаар тушаалаар байгуулжээ.

1.10 Улсын мэргэжлийн хяналтын газраас 2004 онд тус компаний үйл ажиллагааг шалган дүрмийн санг ажилгүйдлийн даатгалын сангийн 4 сая төгрөгөөр бүрдүүлсэн нь буруу гэж үзэн дээрх санд эргүүлэн төлүүлэх шийдвэр гаргасан байна.

1.11 НХХ-ийн сайдын 2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 67 дугаар тушаалаар “Зуучлагч товчоо” ХХК-ийг 25 хувийн төрийн өмчийн оролцоотой ХХК болгож өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ тушаалыг гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 22 дугаар зүйлд “Төрийн өмчит үйлдвэрийн газар ба албан газрыг ЗГ-ын буюу хуулиар тусгайлан олгосон эрх бүхий байгууллагын шийдвэрээр байгуулах . . .” гэж заасныг үндэслэл болгосон нь төрийн өмчийн оролцоотой ХХК байгуулахад хамаарахгүй юм.

1.12 Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчилж, төрийн өмчит компаний 75 хувийг хувийн өмчид шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн “төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах арга хэмжээг ЗГ баталсан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн ба мөн хуулийн 62 дугаар зүйлд “УИХ-ын буюу ЗГ-ын баталсан жагсаалтад ороогүй

объектыг хувьчилсан бол хувьчлалыг хууль бус гэж үзэх”-ээр заасан тул “Зуучлагч товчоо” ХХК хууль бусаар хувьчилсан гэж үзэж болохоор байна.

1.13 “Зуучлагч товчоо” ХХК-ийн дүрэмд компанийн 5,3 сая төгрөгийн дүрмийн сангийн 75 хувийг буюу 4,0 сая төгрөгийн хувьцааг иргэн Д.Сүхбаатар, 25 хувийг буюу 1,3 сая төгрөгийн хувьцааг ХЭГ эзэмшихээр заасан боловч, компани байгуулагдсан үеэс 2004 оны 8 дугаар сар хүртэлх 2 жилийн хугацаанд төрийн өмчийн оролцооны 1,3 сая төгрөгийг шилжүүлээгүй, компанийн дүрэмд заагдсан дүрмийн санг бүрэн бүрдүүлээгүй байна.

1.14 Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-гийн “төлбөр хийгдсэн хувьцааны дүн нь хуулиар тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн бол компани байгуулах нөхцөл бүрдсэн гэж үзнэ”, 15 дугаар зүйлийн 2.5-ын компанийг бүртгүүлэхэд “бүртгүүлэх өдөр байх ёстой хөрөнгийн доод хэмжээг харуулсан эхлэлтийн баланс”-ыг бүрдүүлэх тухай заалт биелэгдээгүй тул “Зуучлагч товчоо” ХХК зохих ёсоор байгуулагдсан, татварын албанд бүртгэгдсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

1.15 ТӨХ-ны 2006 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 488 дугаар тогтоолоор “Зуучлагч товчоо” ХХК-д төрийн өмчийн төлөөллийг томилж, дүрмийн санд оруулах 4,1 сая төгрөгийг ТӨХ-ноос гаргахаар шийдвэрлэсэн байна.

1.16 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах”, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмч хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар тухайн хуулийн этгээдээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэх” нь ЗГ-ын бүрэн эрхэд хамаарахаар заасан атал НХХ-ийн сайд “Зуучлагч товчоо” ХХК-г анх байгуулсан, улмаар төрийн өмчийн оролцоотой ХХК болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гаргасан, төрийн өмчийн оролцоотой компани байгуулах асуудал ЗГ-аар шийдвэрлэгдээгүй байхад ТӨХ төрийн өмчийн төлөөллийг томилсон зэрэг нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй байна.

1.17 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна”, 64 дүгээр зүйлийн “Хувьчлалын орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулна” гэсэн заалтууд болон ТӨХ нь улсын төсөвт төлөх орлогоос батлагдсан төсвийн хэмжээгээр санхүүжиж байгаа зэргээс үзвэл ТӨХ-нд төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн сан бүрдүүлэхэд зарцуулах санхүүжилтийн эх үүсвэр байхгүй юм. Иймд “Зуучлагч товчоо” ХХК-ийн дүрмийн сангийн төрийн өмчид ногдох 4,1 сая төгрөгийг ТӨХ-ноос гаргахаар шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна.

1.18 Өөрөөр хэлбэл “Зуучлагч товчоо” ХХК байгуулагдсан, ажиллаж ирсэн болон одоогийн эрх зүйн байдал нь хуульд нийцэхгүй байна.

1.19 “Зуучлагч товчоо” ХХК-ийн одоогийн статус, өмчийн хэлбэр нь БНСУ-д ажилчид явуулах тухай Монгол Улсын НХХЯ болон БНСУ-ын Хөдөлмөрийн яамны хооронд 2004 оны 5 дугаар сарын 3-нд байгуулсан Харилцан ойлголцлын тунхаг бичгийн 3.1-ийн “Хөдөлмөр эрхлэлтийн зуучлах товчоо нь улсын төсвөөс санхүүждэг НХХЯ-ны салбар байгууллага бөгөөд гадаадад буй монгол ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг зохицуулах хуулийн эрх бүхий байгууллага юм” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Ажиллах хүч гадаадад гаргах тухай гэрээний биелэлт, гадаадад ажиллах иргэнээс авах зуучлалын хураамжийг мөрдөж байгаа эсэх

1.20 Гадаадад ажиллах хүч гаргах зөвшөөрөл бүхий нийт 21 аж ахуйн нэгжээс 14 аж ахуйн нэгжийн гадаад дахь хамтрагч болон гадаадад ажиллах, дадлага хийх иргэдтэй байгуулсан гэрээний биелэлтийг шалгав.

1.21 Зуучлалын компаниуд Монгол Улсын иргэдийн илүү цагийн хөлсийг тухайн орны хуулийн дагуу нэмэгдүүлэн олгох, байр, унаа, ус, цахилгаанаар болон ажлын өдөрт хоолоор үнэгүй хангах, нийгмийн даатгал, ажиллах хүч гаргаж байгаа улсад очих, буцах унааны зардлын талаар иргэдтэй байгуулсан гэрээндээ тусгажээ.

1.22 Харин дадлагажигч ажилтнуудын цалин хөлс, бусад орлогыг тухайн орноос гуйвуулах боломж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас амиа алдсан, тахир дутуу болсон нөхцөлд хохирлыг хэрхэн барагдуулах, эрх ашиг хохироход зуучлагч байгууллага ямар хариуцлага хүлээх талаар гэрээнд тусгаагүй байдал нийтлэг байна.

1.23 Гадаадад гэрээгээр ажиллагсадтай байгуулсан гэрээнд ажиллагсдын насыг 20-35 байх ба цалин хөлсийг тухайн орны цалингийн доод хэмжээнээс доошгүй буюу 500-700 ам.доллараас эхлэн нэмэгдүүлэн олгохоор тогтоосон байна.

1.24 Зуучлагч 5 компанийн зуучлалын дагуу БНУУ, БНЧУ, БНСУ, Япон улсад ажиллаад ирсэн буюу одоо ажиллаж буй 30 иргэний ар гэрийнхэнтэй ярилцаж саналыг нь сонсоход, зуучлагч компаниуд гэрээнд заагдсан үүргээ үндсэнд нь биелүүлсэн гэж хэлж байв.

1.25 Харин “Будын” ХХК БНУУ-д ажиллах монгол иргэдтэй зөвхөн бичиг баримтыг бүрдүүлэх, “Цуки” ХХК Япон улсад ажиллах монгол иргэдтэй зөвхөн мэдээллийг зуучлуулагчид өгөх үүрэг хүлээсэн гэрээ байгуулжээ.

1.26 Хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд ажиллах хүч гадаадад гаргах бүрдээ НХХЯ-аар шийдвэр гаргуулахгүй байгаа нь Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 6.7 дугаар заалтыг зөрчиж байна.

1.27 Ажиллах хүч гадаадад гаргахад үйлчилгээний төлбөрт хүн тус бүрээс 1000-2500 ам.доллар авч байгаа ба энэ нь баримт бичгийн орчуулга, онгоцны тийзийн төлбөр, сургалт, эмнэлгийн үзлэг, визийн хураамж, зуучлалын хөлс зэрэгт зарцуулагдаж байна.

1.28 “Зуучлагч товчоо” ХХК-ийн шугамаар БНСУ-д хөдөлмөр эрхлэхээр явуулж буй иргэнээс авах зардлын хураамжийн дээд хэмжээг НХХ-ийн сайдын 2004 оны 126 дугаар тушаалаар 850 ам доллароор тогтоосон ба 2005 онд “Зуучлагч товчоо” ХХК-ийн захирлын тушаалаар зардлын хураамжийг 1000 ам доллар болгон өөрчлөн тогтоожээ.

1.29 Зуучлалын хураамжийн хэмжээг тогтоосон шийдвэрийг НХХЯ-аар хянуулахаар заасан боловч зөвшөөрөл нэгэнт авснаас хойш орох өөрчлөлтийг дахин хянуулах шаардлага хуульд тусгагдаагүй байна.

1.30 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 6 дугаар зүйлд зуучлах зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө ... зуучлалын хураамжийг хавсаргах, хянуулахаар заасан атал НХХЯ зөвшөөрөл олгохдоо замын зардал, сургалтын зардал, визийн болон зуучлалын хураамжийг багтаасан зардлын хураамжийг хянаж байна.

1.31 “Алтан жолоо” ХХК-ийн аудит хийж, баталгаажуулсан “Зуучлагч товчоо” ХХК-ийн 2004, 2005 оны санхүүгийн тайланд 218,0 сая төгрөгийн ашиг тодорхойлогджээ. Төрийн нэрээр хийгдэж буй зарим ажил үйлчилгээг их хэмжээний ашиг олох хэрэгсэл болгох боломжийг бүрдүүлсэн нь үүнээс харагдаж байна. Зүй нь иргэдээс аль болох бага төлбөр хураамж авч үйлчлэх учиртай.

1.32 “Зуучлагч товчоо” ХХК нь 2005 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар БНСУ дахь төлөөлөгчийн газрын болон хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний өглөгийн дансанд 457.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

1.33 Энэ нь СЭЗ-ийн сайдын 2000 оны 116 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дансны үлгэрчилсэн заавар”-ын 3 дугаар бүлгийн “... хэнд төлөх нь тодорхой өрийг жинхэнэ өр төлбөр гэж үзэх бөгөөд энэ хэмжээгээр балансад тусгана. ...Өр төлбөрийг төлөх ёстой дүнгээр үнэлнэ. Холбогдох хөрөнгө, зардал буюу алдагдлыг хүлээн зөвшөөрсөн үед өр төлбөрийг бүртгэдэг” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.34 Иймд Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-т “100 сая төгрөгөөс дээш төгрөгийн албан татвар ногдох орлогод 15 сая төгрөг дээр 100 сая төгрөгөөс дээш орлогын дүнгийн 30 хувиар нэмж татвар ногдуулна” гэж заасныг үндэслэн 122,2 сая төгрөгийн орлогын албан татварыг “Зуучлагч товчоо” ХХК-иар нөхөн төлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

ЗӨВЛӨМЖ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд:

- Гадаадад ажиллах хүч гаргах ажлыг “Агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуульд нийцүүлэн хэрэгжүүлэгч агентлагаар гүйцэтгүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах
- “Зуучлагч товчоо” ХХК байгуулсан эрх зүйн үндэслэл, одоогийн статусыг холбогдох хуульд нийцүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
- Төрийн нэрийн өмнөөс ажиллах хүч гадаадад зуучлах үйлчилгээ үзүүлсний хураамжийн хэмжээг аль болох багасгахад чиглэгдсэн бодлого, арга хэмжээг цогц байдлаар төлөвлөж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавих

1. Гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож байгаа байдал

2.1 Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, ЗГ-ын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын дагуу Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг 2004 онд 13053, 2005 онд 14283 гадаадын иргэнд олгожээ.

2.2 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг урьдчилан авахдаа салбарын яам, агентлагийн тодорхойлолт авах, тухайн байгууллагад гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах тухай орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албадын санал авах ажил тогтмол хийгдэхгүй байна.

2.3 Гадаадад суугаа Монгол Улсын ЭСЯ, консулын газрын ажилтнууд бизнес ангиллын визийг гадаадын иргэдэд олноор нь олгосон, ХХҮГ-ын ажилтнууд бизнес, жуулчин ангиллын визийг хөдөлмөр эрхлэх ангиллын визэнд хууль бусаар шилжүүлсэн тохиолдлууд аудитын явцад илэрлээ.

2.4 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг зөрчин 2004 онд бизнес ангиллын визтэй 159, жуулчин ангиллын визтэй 3 хүнд ХЭГ-ын дарга асан Б.Жанцан, 2005 оноос 2006 оны эхний хагас жилийн хугацаанд бизнес ангиллын визтэй 541, жуулчин ангиллын визтэй 12 хүнд ХХҮГ-ын дэд дарга Ж.Цогтбаатар хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгожээ.

2.5 ХХҮГ хугацаанаасаа өмнө болон хугацаа нь дуусвар болоод буцаж буй гадаадын иргэдийн хасалт хийлгүүлсэн тухай мэдээллийг ГИХАЭА-наас авахгүй байгаа нь хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн судалгааг бодитой гаргах, ажлын байрны төлбөр төлөлтийг хянах боломжгүй болгож байна.

2. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох тухай ЗГ-ын тогтоолын хэрэгжилт

2.6 Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй компаниуд гадаадын иргэний гүйцэтгэх үүрэг, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажил амралтын цагийн горим, орон сууц ахуй хангамж, нийгмийн даатгал зэрэг асуудлыг зохицуулсан гэрээ байгуулж иржээ.

2.7 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.4-т заасныг үндэслэн гадаадаас авах

ажиллах хүч, мэргэжилтний хувийг аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн хэмжээ, ажиллагсдын тоотой уялдуулан ЗГ-аас жил бүр тогтоож иржээ.

2.8 Аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын тоонд гадаадын ажиллагсдын эзлэх хувийг 2004 онд эдийн засгийн 3 салбарт урьд оноос 4-10 хувиар нэмэгдүүлсэн ба 4 салбарыг шинээр оруулж 4-35 хувь байхаар, 2005 онд 5 салбарт 1-4 хувиар нэмэгдүүлсэн ба машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн салбарыг шинээр оруулан 5-10 хувь, бусад бүх салбарт 5 хувь байхаар нэмэгдүүлж ирсэн бөгөөд 2005 онд төмрийн хүдэр олборлолтын салбарын зарим аж ахуйн нэгжүүдэд 5-17 хувиар бууруулж тогтоожээ.

2.9 Алт болон бусад үнэт металлын эрэл хайгуул, олборлолтын чиглэлийн аж ахуйн нэгжид ажиллах гадаадын ажиллагсдын хувийг 2004-2005 онд 2-10 хувиар нэмэгдүүлж, 2006 онд 23-44 хувь байхаар тогтоосон бол 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно гэж 2-4 дахин бууруулан заасан байна.

2.10 Бараг бүх аж ахуйн нэгж байгууллагаас нийгмийн даатгалын болон хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад гаргаж өгсөн ажиллагсдын тоо зөрүүтэй байгаа нь аудитын явцад илэрлээ. Тухайлбал:

(2005 оны байдлаар)

<i>Аж ахуйн нэгжийн нэр</i>	<i>нийт ажиллагсдын тоо</i>	
	<i>Нийгмийн даатгалын байгууллагад</i>	<i>Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад</i>
Монсикон ХХК	11	191
Богда холдинг ХХК	10	460
Цайрт минерал ХХК	10	850
Насны зам ХХК	9	510
дүн	40	2011

2.11 Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох нэг гол үзүүлэлт болсон нийт ажиллагсдын тоог ХХҮГ тухайн байгууллагын мэдээлснээр авч, тогтоосон хувиас хэтрүүлэн ажиллах хүч авах боломжийг ААНБ-д олгож байна.

2.12 Үндэсний статистикийн газар 2006 онд Монгол Улсад 33,4 мянган аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрт ажилладаг 381.4 мянган хүн тоологдсон гэж дүгнэснээс үзвэл ЗГ-ын дээрх тогтоолын хамгийн бага 5 хувиар тооцоход манай улсад 19.1 мянган гадаадын иргэд ажиллах бололцоотой байгаа нь одоо АБТ төлж ажиллаж буй гадаад ажиллагсдын тооноос 2 дахин их байна.

2.13 Гэтэл 2005 оны байдлаар Монгол Улсад зөвхөн идэвхитэй ажил хайж байгаа ажилгүй иргэн 32.9 мянга байгаа нь гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоож буй үндэслэл, тооцоог хянаж үзэх шаардлагатайг харуулж байна.

2.14 ЗГ-ын дээрх тогтоол Монгол Улсад гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлүүлэх талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх механизм болж чадахгүй байна.

2.15 ЗГ гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоохдоо өөрийн орны ажилгүйдлийн түвшинг харгалзан аль улсын хичнээн иргэнийг авч ажиллуулах шаардлагыг нарийн судалж, тооцоолохгүй байна.

2.16 ЗГ-ын 2004 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 77 дугаар тогтоолоор “Алтан дорнод” ХХК-ийн гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагсдын тоонд эзлэх хувийг 75 хувь болгон нэмэгдүүлж тогтоожээ. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиар гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тогтоохоор заасан атал “Алтан дорнод” ХХК-д тусгайлан тогтоосон нь хуульд нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд:

- Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайханд:

- Гадаадын иргэдэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох ажилд тавих дотоод хяналтыг сайжруулах
- Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч буй ААНБ-ын нийт ажиллагсдын тоог тогтоохдоо нийгмийн даатгалын байгууллагатай хамтарч ажиллах

1. Ажлын байрны төлбөр төлж буй байдал

3.1 Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаадын иргэд 2004-2005 онд 3070,0-3736,0 сая төгрөгийн АБТ төлж, ХЭДС-ийн 2004 оны 89.0 хувь, 2005 оны 96 хувийг бүрдүүлжээ.

ХЭДС-ийн орлогын бүрдэлт

ХЭДС-ийн орлого	/ сая төгрөгөөр /			
	2004 он		2005 он	
	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Төлөв лөгөө	Гүйцэт гэл
Улсын төсвийн санхүүжилт	800	200	-	-
Орон нутгийн төсвийн санхүүжилт		22	-	1.6
Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр	1600	3070.3	2400	3736
Жижиг зээлийн сангийн хүүгийн орлого	100	130.2	120	120.5
Бусад		26.4		15.2
Орлогын дүн	2500	3448.9	2520	3873.3

3.2 2002-2005 онд гадаадын иргэний нэг сард төлөх АБТ-ийн хэмжээ 49,5-85,0 мянган төгрөг, ХЭДС-нд төвлөрүүлсэн АБТ 1458,1-3736,0 сая төгрөг болж нэмэгджээ. Үүнээс үзвэл АБТ-ийн өсөлтийн 1.0 тэрбум нь АБТ-ийн хэмжээ нэмэгдсэнээс, 1,3 тэрбум нь гадаадын ажилчдын тооны өсөлтөөс шалтгаалжээ.

3.3 АБТ-ийн орлого 2004-2005 онд төлөвлөснөөс 91,9-55,7 хувиар нэмэгдсэн нь барилга, уул уурхайн салбарт ажиллах гадаад иргэдийн тоо төлөвлөснөөс 3,9-2,2 мянгаар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.4 Гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олголт, АБТ-ийн тооцоог нягтлан бодох бүртгэлд тусгах ажлын уялдаа муугаас шалтгаалан АБТ-ийг хураамжийн орлогоор бүртгэн ХХҮГ-ын санхүүжилтэд тооцох явдал гарч байна. “Богда холдинг” ХХК-иас төлсөн АБТ-ийн 8,7 сая төгрөг хураамжийн орлогын дансанд орж ХХҮГ-ын санхүүжилтээр тооцогдсон, “Жамп” ХХК 1,3 сая төгрөгийн АБТ дутуу төлсөн нь аудитын явцад тогтоогдсон тул ХЭДС-ийн дансанд оруулах нь зүйтэй.

3.5 АБТ-ийн тооцоог нягтлан бодох бүртгэлд зохих ёсоор тусгаагүй, аж ахуйн нэгж, байгууллагуудын тооцооны үлдэгдлийг гаргаагүй, төлбөл зохих дүнг АБТ-ийн бүртгэлд алдаатай бүртгэсэн нь аудитаар илэрлээ. Тухайлбал “Алтан дорнод” ХХК-ийн АБТ-ийн төлөлтийг 2005 онд 72,8 сая төгрөгөөр, 2004 онд 29,8 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.

3.6 Аудитын явцад АБТ-ийн тооцоог шалган 2004 оны 1408, 2005 оны 1535 гүйлгээг тохируулсан боловч гүйлгээг хольж хөтөлсөн, хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн бүртгэл алдаатайгаас шалтгаалан 2004 оны 422, 2005 оны 266 гүйлгээг шалгаагүй тул дахин шалгаж тохируулах шаардлагатай байна.

3.7 ЗГ-ын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-д “Тухайн байгууллага хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг 5 хүртэл гадаадын иргэнд авах тохиолдолд АБТ-ийг урьдчилан төлөх ба түүнээс дээш тооны гадаадын иргэдийн хувьд АБТ-ийг төлөх хугацаа, нөхцөлийн талаар хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагатай харилцан тохиролцож гэрээний дагуу төлж болно” гэж заасныг үндэслэн 2004 онд 15, 2005 онд 9 аж ахуйн нэгжээс АБТ-ийг графикаар авч иржээ.

3.8 Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын дийлэнх нь 5-аас дээш тооны иргэдийг ажиллуулж байгаа тул графикаар төлөх бололцоотой байна. Өнгөрсөн хугацаанд графикаар төлүүлэх байгууллага, хугацаа, нөхцөлийг тогтоосон журамгүй ажиллаж ирсэн нь АБТ-ийг бүртгэх, хянахад бэрхшээл учруулж байна.

3.9 АБТ-ийг графикаар төлж буй байгууллагуудаас 2004-2005 онд авах 101,6-229,7 сая төгрөгийн авлага, халагдсан, ээлжийн амралтаа авсан иргэдийн АБТ-ийн тооцоолол нягтлан бодох бүртгэлд тусгагдахгүй бүртгэл хяналтаас гадуур орхигдож байна.

3.10 Тухайлбал “Интернэшнл билдинг” ХХК-иар АБТ-ийг графикаар төлүүлэх шийдвэр гаргасан боловч түүнд хяналт тавих ажил орхигдсоноос, тус компани дампуурсан шалтгаанаар 28,9 сая төгрөгийн АБТ төлүүлээгүй байна.

3.11 “Алтан дорнод” ХХК “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 2 дугаар зүйлийн 4-т “Байгууллага нь. . хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагаас гадаадын иргэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахдаа АБТ төлнө” гэж заасныг зөрчиж, АБТ төлөхдөө 2004, 2005 онуудад ээлжийн амралтаа авсан гадаадын ажилтнуудынхаа нийт 838.0 сая төгрөгийн АБТ-ийг хасуулж тооцож ирсэн тул энэ асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2. АБТ-ийг ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээнд зарцуулж буй байдал

ХЭДС-гийн зарцуулалтыг харуулбал:

/сая төгрөгөөр/

ХЭДС-гийн зарцуулалт	2004 он		2005 он	
	Төлөв лөгөө	Гүйцэт Гэл	Төлөв лөгөө	Гүйцэт гэл
Орлогын дүн	2500	3448.9	2520	3873.3
Иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	114.3	68.5	65.2	94.2
Ажилд зуучлах	134.5	112.9	68.3	94.1
Мэргэжил олгох давтан сургалт	814.5	870.7	780.1	787.8
Нийтийг хамарсан ажил зохион	818	740.5	610.4	678.3

байгуулах				
Жижиг зээл олгох	810	810	892.8	896.5
Ажил олгогчийг дэмжих	281	221.7	360.6	274.5
Хөдөлмөрийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх	359.6	369.6	268.4	300.3
Ажилтнуудын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх	32.6	39.9	-	-
Жижиг зээлийн үйл ажиллагааны болон бизнес инкубатор төвийн зардал	35.2	45.5	-	-
Зарлагын дүн	3400	3279.3	3049.8	3125.8

3.12 ЗГ-ын 2001 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “ХЭДС-г бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д сангийн зарлагыг төлөвлөхдөө сургалтын зардалд нийт орлогын 20 хүртэл, жижиг зээл олгох арга хэмжээнд 30 хүртэл, нийтийг хамарсан ажил зохион байгуулахад 15 хүртэл хувийг зарцуулахаар заажээ. Гэтэл 2004-2005 онд сургалтад 32.5-30.9 хувь, жижиг зээл олгоход 32.4-35.4 хувь, нийтийг хамарсан ажилд 32.6-24.2 хувь буюу тогтоолд зааснаас нийт 682.5-645.3 сая төгрөг илүү зарцуулахаар төлөвлөсөн төдийгүй ийнхүү илүү төлөвлөснөөс 2004 онд сургалтад 56.2 сая төгрөг, 2005 онд нийтийг хамарсан ажилд 67.9 сая төгрөгийг илүү зарцуулжээ.

3.13 ХХҮГ-ын Сургалт арга зүйн хэлтсийн гаргаж өгсөн мэдээллээс үзвэл мэргэжил олгох давтан сургалтад 2004-2005 онд 23.1-19.5 мянган хүнийг хамруулж бүгд 855.2-787.8 сая төгрөг, нэг хүнд 37.0-40.0 мянган төгрөг зарцуулжээ. ХЭДС-гаас санхүүжих эрх бүхий итгэмжлэгдсэн 100 гаруй сургалтын байгууллагад 40 гаруй төрлийн мэргэжил олгох, давтан сургах ажлыг зохион байгуулж, оролцогчдын 59,6-53,9 хувь буюу 13,4-10,5 мянган хүнийг ажлын байраар хангасан байна. 2004-2005 онд 2,1-1,5 мянган худалдагч нярав, 3,0-1,9 мянган тогооч нарийн боовчин, 1,2-1,1 мянган оёдол, эсгүүрчин, барилгын төрөл бүрийн мэргэжлээр 4,3-2,1 мянган ажилчдыг бэлтгэсэн нь сургалтад хамрагдаж мэргэжил эзэмшигчдын 77,3-41,2 хувь болж байна.

3.14 ХЭДС-гаас зам гүүр засах, ой цэвэрлэх, хог хаягдал зайлуулах, тохижилт, барилга засварын үйлчилгээ хийх зэрэг нийтийг хамарсан ажилд 2004-2005 онд 21,9-17,9 мянган хүнийг хамруулан, бүгд 740,5-678,3 сая төгрөг, нэг хүнд цалин, НДШ-д 33.8-37.8 мянган төгрөгийг олгожээ.

3.15 Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 278-326 ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж, тэдгээрт 6 сарын цалингийн 60 хувийн нөхөн төлбөрт 2004 онд 1106 хүний 208,6 сая төгрөг, 2005 онд 1118 хүний 264,5 сая төгрөгийг олгожээ.

3.16 ХЭДС-гаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 2004-2005 онд 3.3-3.1 тэрбум төгрөг зарцуулсан, улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж буй боловч нэгдсэн бодлого, зохицуулалт дутагдсанаас ажилгүйдэл 35.6-32.9 мянгад хүрч мэдэгдэхүйц буурахгүй байна.

3.17 Ажлын үр дүн ийм байхад 2004 онд ХЭА-д машин худалдан авахад 55.5 сая төгрөг, албадыг тавилга, техник хэрэгслээр хангахад 210.0 сая төгрөг зарцуулан, 2005 онд ХХҮГ-ын албан хэрэгцээнд ТӨХ-ны тогтоолоор 58.1 сая төгрөгийн Ланд Круйзер маркийн автомашин, 77.6 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж авч, 73.0 сая төгрөгийн барилга засварын ажил хийн ХЭДС-гаас

дээрх арга хэмжээнд зарцуулахаар батлагдсан төсвийг 76.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

3.18 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор жижиг зээл олгоход ХЭДС-гаас банк, ББСБ-д байршуулах хөрөнгийг 2004-2005 онд 810,0-896,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2004 онд 6 банк, 6 ББСБ-д 1,6 тэрбум төгрөг, 2005 онд 4 банк, 12 ББСБ-д 2,5 тэрбум төгрөг байршуулжээ.

3.19 Банк, ББСБ-ууд 2004-2005 онд 1.5-2.2 мянган аж ахуйн нэгж, иргэн, малчин өрхийн бүлэгт зээл олгосноор тайлагнасан ба зээл олгосон аж ахуйн нэгж, иргэн, зээлийн дүнг ХЭА-даас гаргуулан авч үзвэл 2004-2005 онд 1.8-2.0 тэрбум төгрөгийн зээлийг 1-1,3 мянган хүнд олгосон байгаа нь банк, ББСБ-ууд гэрээнд заасны дагуу ХЭА-дын тодорхойлсон иргэн, аж ахуйн нэгжид зээл олгохгүй гэрээний үүргээ зөрчиж байгааг харуулж байна.

3.20 Банк, ББСБ-уудад байршуулсан хөрөнгөөс жижиг зээлд олгогдоогүй үлдэгдэл 2004 онд 202,2 сая төгрөг байсан бол 2005 онд 960,4 сая төгрөгт хүрчээ. Тухайлбал Анод банк 2005 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 500 сая төгрөг авч ашигласан боловч банкны өөрийн тайлангаар зориулалтын дагуу 4 сая төгрөгийн зээл олгож бусдыг өөрийн үйл ажиллагаанд ашиглаж байжээ.

3.21 2004-2005 онд жижиг зээлийн сангийн хүүгийн орлогоор ХЭДС-д 130.2-120.5 сая төгрөг орж байжээ. Гэтэл ЗГ-ын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх журам”-д ХЭДС-гаас банк, ББСБ-тай жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа байршуулсан хөрөнгөд хүү авах тухай тусгаагүй тул 2006 онд гэрээг хүү авахгүйгээр хийжээ.

3.22 ҮХ-ны сайд, НХХ-ийн сайдын 2003 оны 67/62 дугаар тушаалаар Сэлэнгэ, Булган, Хэнтий, Завхан, Дорнод аймагт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн чиглэлийн дагуу Төв аймагт ХЭА-даар дамжуулан зээл олгох үйл ажиллагаа эхлүүлэн 2004 онд 130 сая төгрөг байршуулж 290,9 сая төгрөг, 2005 онд 150 сая төгрөг байршуулж 69,7 сая төгрөгийн зээл олгожээ.

АБТ-ийн хөнгөлөлт, чөлөөлөлт

3.23 2004 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын иргэдийн 35,1 хувь буюу 4594 иргэнийг, 2005 онд 32,9 хувь буюу 4705 иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлжээ. 2004-2005 онд АБТ-өөс чөлөөлөгдсөн иргэдийг хуулийн заалтаар нь ангилбал:

<i>АБТ-өөс чөлөөлөгдсөн иргэд</i>	<i>2004 он</i>	<i>2005 он</i>
Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтан	18	3
ОУБ-ын суурин төлөөлөгчийн газрын ажилтан	113	129
МУ-ын гэрээ, ТЗТБ-тай хийсэн гэрээ, хэлэлцээрийн дагуу ажиллаж буй ажилтнууд	121	49
ЗГ хоорондын гэрээний дагуу ажиллаж буй ажилтан	85	90
МУ-д хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй гадаадын ТББ-ын ажилтнууд	758	774

Боловсрол, ШУ-ны салбарт гэрээгээр ажиллаж буй гадаадын мэргэжилтэн, ажилтнууд	824	896
МУ-д хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач иргэд	10	23
Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцож буй ажиллагсад	2424	2530
ГХОААН-ийн хөрөнгө оруулагч, удирдах ажилтан	241	211
Бүгд	4594	4705

3.24 Аудитын явцад ЗГ-ын тогтоол зөрчин дотоодын ТББ-ын урилгаар ирж ажиллаж буй гадаадын иргэд болон ЗГ-ын хэрэгжүүлж буй улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр нэрийн дор хувийн салбарын хамтран хэрэгжүүлж буй төслийг АБТ-өөс чөлөөлсөн, яам, ЗГ-ын агентлагтай байгуулсан гэрээгүй, тэдэнтэй хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, судалгаа шинжилгээний ажлын шугамаар ирээгүй гадаадын иргэдийг АБТ-өөс чөлөөлсөн, хөнгөлсөн зөрчил илэрлээ.

3.25 Дотоодын ТББ-ын шугамаар ирж буй гадаадын иргэдийг АБТ-өөс чөлөөлөх явдал нилээд түгээмэл шинжтэй болсон бөгөөд зарим ТББ-ын нэр дээр гадаадын ажилчдыг ажиллуулж АБТ-өөс зайлсхийх явдал гарчээ.

3.26 2004-2005 онд дотоодын 75 ТББ-ын нэрээр 120 хүн манай улсад уригдан ирж ажилласан ба энэ тоо эрс өсөх хандлагатай байгааг харгалзан 2006 онд олон хүн урьж ажиллуулсан зарим байгууллагыг түүвэрлэн шалгалаа.

3.27 2006 оны 3 дугаар сард “Монголын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн холбоо” ТББ 20 хятад иргэнийг 8 сар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авч 16.9 сая төгрөгийн, 2006 оны 7 дугаар сард “Шатрын мастеруудын холбоо”, “Монголын ажил хэрэгч эмэгтэйчүүдийн холбоо” зэрэг 7 ТББ бүгд 156 хятад иргэнийг 7 сар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авч 109.1 сая төгрөгийн, “Монгол нутгийн салхи төв”, “Монголын хоккейн холбоо” зэрэг 9 ТББ 45 хятад иргэнийг 6-7 сарын хугацаагаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авч 36.6 сая төгрөгийн АБТ-өөс чөлөөлүүлснийг нөхөн төлүүлэх нь зүйтэй юм.

3.28 2004-2005 онд ЗГ-ын тогтоол, НХХ-ийн сайдын тушаалаар нийт 3880 ажилчны 2754 сая төгрөгийн АБТ-ийг чөлөөлж, хөнгөлөлт үзүүлжээ. “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 12 дугаар зүйлийн 1-ын “Яам, ЗГ-ын агентлагийн байгуулсан гэрээ, албан ёсны урилгын дагуу гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд НХХЯ-ны шийдвэрээр АБТ-өөс 50 хувь чөлөөлөх” тухай заалтыг зөрчиж

- “СНМ” ХХК-д ажиллах 27 хятад иргэнийг НХХ-ийн сайдын 2004.04.27-ны 73 дугаар тушаалаар 2004.04.01-нээс 2004.10.31-ний өдрийг хүртэл;
- “Богда холдинг” ХХК-д ажиллах нийт 300 хятад иргэнийг НХХ-ийн сайдын 2003.06.04-ний 86 дугаар тушаалаар 2003.05.01-нээс 2004.12.31-ний өдрийг хүртэл;
- “Алтан дорнод” ХХК-ийн 520 ажилтныг НХХ-ийн сайдын 2004.04.08-ны 63 дугаар тушаалаар 2004.03.01-нээс 2004.12.31-ний өдрийг хүртэл

АБТ-өөс 50 хувиар хөнгөлсөн байх тул 5.4 сая төгрөгийг “СНМ” ХХК-иар, 41 сая төгрөгийг “Богда холдинг” ХХК-иар, 208,0 сая төгрөгийг “Алтан дорнод” ХХК-иар нөхөн төлүүлэх нь зүйтэй байна.

3.29 2003 оны 5 дугаар сард болсон Монгол-Оросын ЗГ хоорондын Худалдаа, эдийн засгийн болон шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны комиссын 10 дугаар хуралдааны протоколд Оросын талын хөрөнгө оруулалттай монголын компаниудын гадаадаас авсан ажиллах хүч, мэргэжилтнийг АБТ-өөс хөнгөлөлт үзүүлж байхаар Оросын талаас тавьсан саналыг авч үзэн, ЗГ-ын 2004 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд **асуудлыг судлан, зохих журмын дагуу шийдвэрлэх** гэж тусгагдсан бөгөөд ЗГ-ын шийдвэр гараагүй байхад зөвхөн хуралдааны тэмдэглэлийг дурдан “Алтан дорнод” ХХК-ийн 520 ажилтныг АБТ-өөс чөлөөлсөн нь буруу байна.

3.30 “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ыг үндэслэн, улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж 2005 онд Налайх-Чойрын 200 км замд 570, Эрдэнэт -Булган -Уньтын 146 км замд 305, Тайширын УЦС-д 288, Дөргөний УЦС-д 280 гадаад иргэнийг тус тус ажлын байрны төлбөрөөс чөлөөлөн ажиллуулжээ.

3.31 “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 11 дүгээр заалтад “Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх барилга байгууламж барих, байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүч, мэргэжилтнийг ЗГ-ын шийдвэрийн дагуу авч ажиллуулах тохиолдолд ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө” гэж заасныг баримтлан ЗГ-ын 2003 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Монгол-Хятадын хамтарсан “Цайрт минерал” ХХК-д ажиллах 945 ажилтныг 2004.01.01-нээс 2005.12.31-ний өдрийг хүртэл АБТ-өөс чөлөөлөхөөр шийдвэрлэжээ. Үүний дагуу “Цайрт минерал” ХХК 2004 онд 903 хүний хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах, 11 хүний сунгалт хийлгэхэд болон 2005 онд 492 хүний зөвшөөрөл авах, 17 хүний сунгалт хийлгэхдээ АБТ-өөс чөлөөлөгдсөн байна.

3.32 Гэтэл уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олгож буй хөнгөлөлттэй зээлийн жинхэнэ хэрэглэгч /зээлдэгч/ нь Хятадын өнгөт төмөрлөгийн гадаад барилга, зураг төслийн компани, монголын талын хамтрагч Монгол-Хятадын хамтарсан компани нь хувийн өмчийн компани тул “Цайрт минерал” ХХК АБТ-өөс чөлөөлөгдөх үндэслэлгүй байна. ЗГ-ын дээрх тогтоолын төсөлд СЭЗ-ийн сайд асан Ч.Улаан АБТ-өөс чөлөөлөгдсөн хөрөнгийг Монголын талын хувь оролцоонд тооцох санал өгч байжээ.

3.33 Иймд Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх “Аж ахуйн нэгж байгууллага иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөр” төлөх заалт, ЗГ-ын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-д нийцүүлэн 539,6 сая төгрөгийн ажлын байрны төлбөрийг “Цайрт минерал” ХХК-иар нөхөн төлүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд:

- ЗГ-ын томоохон төсөл хөтөлбөр гэдэгт юуг хамааруулах, Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийг ээлжийн амралтаа авахад нь АБТ-өөс чөлөөлөх эсэх талаар зохих журмын дагуу тайлбар гаргуулах
- ХЭДС-гийн зарцуулалтын үр дүнг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинтэй уялдуулан үнэлэх журам тогтоох
- Ажлын байрны төлбөрөөс холбогдох хууль, ЗГ-ын тогтоол зөрчин хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн шийдвэрүүдийг хянуулж хүчингүй болгох арга хэмжээ авах

ХХҮГ-ын дарга Д.Баярсайханд:

- Хөдөлмөр эрхлэлтийн болон санхүү хяналтын хэлтсийн ажлын уялдааг сайжруулж, АБТ-ийн тооцоонд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, жижиг зээл олгох зорилгоор Банк, ББСБ-д байршуулсан хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг дээшлүүлэх

1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах бодлого чиглэл боловсруулж, хэрэгжүүлсэн байдал

4.1 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлаар бодлого чиглэл тодорхойлж хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ.

4.2 ЗГ-аас 2003 онд “Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг” боловсруулж уг баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг 2004-2005 онд багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 2001 онд батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”, “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ыг боловсронгуй болгох ажил хийгдээгүй байна.

4.3 ХЭГ ажиллах хүч гадаадад гаргах асуудлыг хариуцаж байхдаа 2001 оны 12 дугаар сард Ливан улстай, 2002 оны 10 дугаар сард Тайваний Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын захиргаатай гэрээ байгуулж, БНСУ, ХБНГУ, БНУУ-д ажиллах хүч гаргах хэлэлцээрийн төсөл, төлөвлөгөө боловсруулж байжээ. 2004 оны 10 сар хүртэлх хугацаанд гадаадад ажиллах хүч зуучлагч 21 компани 2631 хүнийг ажиллах хүч, дадлагажигчаар гадаадад гаргажээ.

4.4 НХХЯ хөдөлмөрийн асуудлаар ЗГ-ын хэмжээнд 2004 онд БНСУ-тай харилцан ойлголцлын санамж бичиг, 1998 онд Япон улсын “Житко” байгууллагатай санамж бичиг, 1999 онд БНЧУ-тай ажиллах хүч харилцан солилцох хэлэлцээр байгуулсан байна.

4.5 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 6.8-т зааснаар НХХЯ гадаадад ажиллахаар явсан иргэдийн нэрсийн жагсаалт, гэрээ, холбогдох материалын нэг хувийг тухайн оронд суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, консул, төлөөлөгчийн газарт хүргүүлэх ёстой атал энэ ажил хийгдэхгүй байна.

4.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд “төр хүн амын хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх”, “ажилд зуучлах гэж ажилд орохыг хүссэн иргэнд ... тохирсон ажил санал болгохыг хэлнэ”, “ажилд зуучлах төрийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна” гэж заажээ. Гэтэл Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд Монгол Улсын иргэдийг гадаадад ажилд зуучлах тухай заасан нь дээрх хуультай давхардаж, зуучлахдаа хураамж авахаар заасан нь зөрчилдөж байна. Дотоод болон гадаадад ажиллах хүч зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай

хуулийн агуулгад багтах тул эдгээр хуулиудын уялдааг сайжруулах нь зүйтэй байна.

4.7 Гадаадад ажиллах хүч, дадлагажигчаар ажиллаж буй монгол иргэд, үндсэн мэргэжилтэйгээ огт уялдаагүй ажил хийдгээс өмнө нь эзэмшсэн мэргэшлээ дээшлүүлж эх орондоо ашиглах боломжгүй болж байна. Иймд гадаадад ажиллах хүч, дадлагажигчаар ямар боловсрол, мэргэжилтэй, хэдэн настай иргэдийг явуулах талаархи төрийн бодлогыг тодорхойлох шаардлагатай байна.

4.8 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, тоног төхөөрөмж угсрах, засварлах, төсөл хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажил, мэргэжлээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах гэрээг байгуулж болно” гэж заасан. Гэтэл гадаадаас ирж буй ажилчдын дийлэнх нь энэ зорилтод нийцэхгүй байна.

4.9 Хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл 2004-2005 онд техник ажилтан, бусад холбогдох мэргэжилтнүүд 1.7-2.3 мянга буюу 32.8-40.9 хувь, зөвлөх мэргэжилтнүүд 1.0-1.3 мянга буюу 19.7-23.2 хувь байна.

4.10 Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг хөрөнгө оруулалт, дүрмийн сан, тухайн байгууллагын нийт ажиллагчдад эзлэх хувийн жинтэй харьцуулан эдийн засгийн салбар бүрээр ЗГ-аас жил бүр тогтоож байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй байна.

4.11 Монгол Улсад хөдөлмөр эрхлэгч гадаад иргэдийн тоо өссөөр байгаа, тэдний дундаж цалин монгол иргэдийн дундаж цалингаас дээгүүр байгаа нь АБТ-ийг нэмэгдүүлэн хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж өөрийн орны иргэдийн ажиллах бололцоог хангахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

4.12 Газрын тосны хайгуулын Соко компани 2002-2005 онуудад 24-117 гадаад ажилчидтай байжээ. ЗГ-аас 2005 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг нефть олборлолтын салбарт 90 хувь байхаар шийдвэрлэж, ажиллагсдын тооны дээд хэмжээг тогтоож өгөөгүйгээс Соко компанийн хайгуулын эрхийг авсан Петро чайна компани их хэмжээний хятад ажилчид авч ажиллуулах боломжтой болж байна. Тухайлбал: хятад ажилчдын тоо 2006 онд зарим сард 1 мянга хүрч байжээ.

4.13 Ашигт малтмалын тухай хуульд энэ талаар тусган тус салбарын аж ахуйн нэгжүүд ажиллагсдын 10 хувиас дээш тооны гадаадын иргэдийг авч ажиллуулсан нөхцөлд АБТ-ийг 10 дахин нэмэгдүүлж авахаар заажээ.

2. Элчин сайдын яам, консул, төлөөлөгчийн газар болон холбогдох бусад байгууллагууд хуулийг хэрэгжүүлж буй байдал

4.14 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд тухайн оронд суугаа Элчин сайдын яам, консул төлөөлөгчийн газар Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэх тухай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавих, тэдгээр иргэдийн талаар бүртгэл, мэдээлэл хөтөлж хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, Монгол Улсад орох виз олгоход

хяналт тавих үүрэгтэй гэж заасан байдаг. Гэтэл Монгол Улсын ЭСЯ үнэн хэрэгтээ виз олгохоос хэтэрч ажиллаж чадахгүй байна.

ХХҮГ болон ГИХАЭА-ны ажлын уялдаа муу, хамтарсан хяналт дутагдсанаас шалтгаалан:

- “Икс ди эф” ХХК-д ажиллах 102 хятад иргэнд 2 сар хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай ХХҮГ-ын дэд дарга Ж.Цогтбаатар гэсэн гарын үсэгтэй 2006 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 5/4518 дугаар албан тоотыг үндэслэн ГИХАЭА оршин суух зөвшөөрөл олгожээ. Гэтэл ХХҮГ-ын бичиг хэргийн бүртгэлд тусгасан 5/4518 дугаар албан тоот нь “Нью Фрэнд” ХХК-ийн хасалтын тоот байгаа тул дээрх хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон албан тоотыг хуурамчаар үйлдэж 21,6 сая төгрөгийн АБТ-өөс;
- “Лианошинан” ХХК-д ажиллах 16 хятад иргэнд 6 сар хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай ХХҮГ-ын дэд дарга Ж.Цогтбаатар гэсэн гарын үсэгтэй 2006 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 5/5281 дугаар албан тоотыг үндэслэн ГИХАЭА оршин суух зөвшөөрөл олгожээ. Гэтэл ХХҮГ-ын бичиг хэргийн бүртгэлд тусгасан 5/5281 дугаар албан тоот нь “Монроуд” ХХК-ийн хасалтын тоот байгаа тул дээрх хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон албан тоотыг хуурамчаар үйлдэж 10,2 сая төгрөгийн АБТ-өөс;
- “Монголхо-Цэн” ХХК-д ажиллах 20 хятад иргэнд 6 сар хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай ХХҮГ-ын дэд дарга Ж.Цогтбаатар гэсэн гарын үсэгтэй 2006 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 5/2039 дугаар албан тоотыг үндэслэн ГИХАЭА оршин суух зөвшөөрөл олгожээ. Гэтэл ХХҮГ-ын бичиг хэргийн бүртгэлд тусгасан 5/2039 дугаар албан тоот нь “Олон улсын энэрлийн байгууллага” ТББ-ын хасалтын тоот байгаа тул дээрх хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон албан тоотыг хуурамчаар үйлдэж 12,7 сая төгрөгийн АБТ-өөс чөлөөлөгдсөн нь аудитаар илэрлээ.

4.15 Иймд дээрх компаниудаар АБТ-ийг нөхөн төлүүлж, хуурамч бичиг үйлдсэн асуудлыг хуулийн байгууллагаар шалгуулан, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох нь зүйтэй гэж үзэв.

ЗӨВЛӨМЖ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиудын зөрчилтэй заалтуудыг нэг мөр болгох асуудлыг боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
- Гадаадын иргэдийн АБТ-ийг нэмэгдүүлэн хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтэнд тавих мэдлэг, мэргэшлийн шаардлагыг дээшлүүлэх санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
- ХХҮГ болон ГИХАЭА-ны ажлын уялдааг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Хуурамч бичиг баримтаар АБТ-өөс чөлөөлөгдсөн асуудлыг цагдаагийн байгууллагад шилжүүлж шалгуулах

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

210646 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5,
утас: 26-15-53, факс: 32-86-34, E-mail: Mswl@mongolnet.mn

2006.12.15 № 1/2128
танай _____-ны № _____-г

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Л.ЖАВЗМАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Аудитын гүйцэтгэлийн тайланд дор дурдсан зүйлүүдийг нэмж тусгуулах саналтай байна. Үүнд:

1. Хууль бусаар ажиллаж байсан "Зуучлагч товчоо" нэртэй байгууллагын одоогийн өмчийн эзэн нь хэн болох, мөн санхүүгийн үйл ажиллагаанд нь гарсан зөрчлийг хэн хариуцаж барагдуулах асуудлын талаар тодруулах
2. Цаашид БНСУ-д ажиллах хүч гаргах асуудлыг хэрхэн оновчтой зохион байгуулах, энэ ажилд "Зуучлагч товчоо"-г хэрхэн оролцуулах талаар зөвлөмж өгөх
3. УИХ-д өргөн барихаар бэлтгээд буй "Гадаад хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль"-ийн төсөлд ажлын байрны хураамжийн хэмжээ болон түүнээс чөлөөлөх нөхцлийн талаарх Аудитын газрын санал өгөх

Энэхүү хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын шалгалт мэргэжлийн өндөр түвшинд явагдаж, бодитой дүгнэлт гаргасан гэж үзэж байна.



Л.ОДОНЧИМЭД

08 823

Үндэсний аудитын газрын тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2-т заасныг үндэслэн дараахь тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1

НХХ-ийн сайд Л.Одончимэдэд “Зуучлагч товчоо” ХХК-г байгуулсан эрх зүйн үндэслэл, одоогийн статусыг холбогдох хуульд нийцүүлэх асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгч, санхүүгийн үйл ажиллагаанд гарсан зөрчлийг барагдуулах үүргийг компанийн одоогийн удирдлагад хариуцуулсан болно.

Тайлбар 2

Гадаадад ажиллах хүч гаргах ажлыг Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хэрэгжүүлэгч агентлагаар гүйцэтгүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах шаардлагатайг тайланд дурьдсан байгаа.

Тайлбар 3

ҮАГ-т хуулийн төслийг ирүүлээгүй тул санал өгөх боломжгүй байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хувьсгалчдын гудамж 14, Утас: 26-02-19, Факс: 32-79-06
E-mail: ceo@mongolnet.mn

2006.12.19 № 41250
танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
2 ДУГААР ГАЗРЫН ДАРГА
О.МЭНДБАЯР ТАНАА

Тайлбар, санал

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд танай газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараахь тайлбар, саналыг гаргаж байна.

Үүнд:

1. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч буй байдлын талаар

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Засгийн газрын 2001 оны Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмын дагуу 2004, 2005 онд Засгийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам өөрийн бүрэн эрхийн хүрээнд улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч, стратегийн шинжтэй хөрөнгө оруулагч нэр бүхий компаниуд болон дотоодын зарим төрийн бус байгууллагуудад уригдан ажиллаж буй гадаадын иргэдийг ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулахаар шийдвэрлэснийг тус агентлаг хэрэгжүүлсэн юм.

Дотоодын төрийн бус байгууллагуудад гадаадын ижил төстэй төрийн бус байгууллагуудын нэгэн адилаар өндөр мэргэжлийн мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах бодлогыг дэмжин хэрэгжүүлж, ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулснаар Монгол Улсад шинэ тутам үүсч, хөгжиж буй иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, үндэсний боловсон хүчнийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр болж байна.

Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд тус агентлагаас тавих шууд хяналт хуулиар хязгаарлагдмал, хөдөлмөрийн улсын байцаагчийн эрхгүй зэргээс шалтгаалан аливаа зөрчил, дутагдлыг илрүүлэх, таслан зогсоход хүндрэлтэй ч өөрийн эрх хэмжээний хүрээнд УМХГ, ГИХАЭА, ТЕГ, ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албатай хамтран ажилласны үр дүнд бизнес болон жуулчин ангиллын визтэй зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлэгчдийг илрүүлж, албадан гаргах, ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

ГИХАЭА-тай зөвшилцөн визийн зөрчилтэй хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг ийнхүү шийдвэрлэсэнээр хууль бусаар хөдөлмөр эрхлэх, ажлын байрны төлбөрөөс зайлсхийх явдлыг таслан зогсоох, улмаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэлтэд эергээр нөлөөлж байна.

Цаашид хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд визийн журмыг хөнгөвчлөх, ажлын байрны төлбөр төлөх тооцох, хойшлуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэрэг журмыг шинэчлэх, хөдөлмөр эрхлэлтийн квотыг уян хатан болгох, нийгмийн даатгалын болон хууль, хяналтын байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтын

52619

ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

2. Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг хэрэгжүүлж буй байдал

2004, 2005 онд Засгийн газрын тусгай сан - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэхэд тус газрын хамт олон идэвхи санаачилгатай ажилласан бөгөөд сангийн орлогын өсөлтийг зөвхөн гадаадын иргэдийн тоо , хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбон тайлбарлах нь өрөөсгөл юм.

Тус газар дээрх хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсвийн дагуу сангийн хөрөнгийг захиран зарцуулж, өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ирлээ.

2004 онд сургалтанд 56,2 сая төгрөг илүү зарцуулсан нь сургалтын байгууллагын эрхийг хавтгайруулан ойлгож , сургалтыг өргөн хэмжээнд хийж байсан , нөгөө талаар ажилд зуучуулагсдын ур чадвар ажил олгогчийн шаардлагад нийцэхгүй байсан бодит шалтгаантай холбоотой. Тус газрын 2005 онд УМХГ-тай хамтран сургалтын байгууллагуудыг аттестатчилж, улмаар сургалтын байгууллагуудын дунд төндөр зарлаж, сургалт явуулах зайлшгүй шаардлагатай мэргэжлийн ангиллыг судалгааны үндсэн дээр гаргаж, сургалтын чанар, материаллаг баазын бэхжилт, боловсон хүчний чадвар зэргийг харгалзан сургалтын эрхийг олгож эхэлсэн нь үр дүнгээ өгч байна.

2005 онд нийтийг хамарсан ажилд 67,9 сая төгрөгийг илүү зарцуулсан нь "Ногоон хэрэм", "Мянганы зам" зэрэг бүтээн байгуулалтын ажилд ажилгүй, нэн ядуу иргэдийг татан оролцуулах замаар түр ажлын байраар хангах Засгийн газрын шийдвэрийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан нэмэлт төсвийн хүрээнд хийгдсэн ажил юм.

Ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг дунд , бичил бизнесийг хөгжүүлэх амьжиргааг дэмжих төрийн бодлогын хүрээнд хийгдэж буй нэг чухал ажил бол ХЭДС-аас банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан олгодог бага хүүтэй зээлийн бүтээгдхүүн юм. Энэхүү зээлд хамрагдагсдын хүрээг өргөтгөх, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор 2005 онд хөдөө орон нутагт салбар нэгжтэй, сүлжээ өргөнтэй , уян хатан, чанартай, шинэлэг үйлчилгээтэй 4 банк, 12 банк бус санхүүгийн байгууллагыг төндөрт шалгаруулсан бөгөөд эх үүсвэр байршуулсан өнгөрсөн нэг жилийн хугацаанд 2 тэрбум 390 сая төгрөгийг 1444 иргэн , 25 аж ахуйн нэгж, 221 өрх, 46 малчин өрхийн бүлэгт хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож, нийтдээ 3719 шинэ ажлын байр бий болгосон зэрэг ажлын бодит үр дүнг үгүйсгэж банк, банк бус санхүүгийн байгууллагуудыг дэмжих арга хэмжээ мэтээр дүгнэж буйтай санал нийлэхгүй байна.

2004, 2005 онд ХЭДС-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 3.3-3.1 тэрбум төгрөг зарцуулсан боловч ажилгүйдлийн түвшин буурахгүй байна гэж дүгнэсэн нь олон талтай юм. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төлөв байдлын мэдээллээс үзэхэд ажилд зуучилагчдын тоо 2005 оны 10-р сард 32082, 2006 оны 10 сард 32349 хүн байсан бол ажилгүйдлийн түвшин мөн үетэй харьцуулахад 3.5-3.4% хүртэл тогтвортой буурч иржээ.

Гэтэл жил бүр их, дээд сургууль, 8,10 дугаар анги ,МСҮТ-ийг төгсөгчид болон цэргээс халагдсан, шоронгоос суллагдсан зэрэг олон мянган хүн ажилгүйчүүдийн эгнээг тогтмол өсгөж байдгаас ажилгүйдлийг бууруулах асуудлыг санхүүгийн хязгаарлагдмал боломжтой ганц агентлагын үйл ажиллагаатай холбон тайлбарлах нь учир дутагдалтай юм.

Цаашид Засгийн газар, яам, агентлагуудын дэргэдэх ижил төстэй байгууллага, сангуудын хамтын хүчин чармайлт, төрийн нэгдсэн бодлогоор хангаж байж ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад дорвитой ахиц гарах болно.

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолоор Улсын нийгмийн халамжийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн газрыг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрыг байгуулсан бөгөөд нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаархи төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэсэн билээ.

УНХГ-ын автомашин эвдэрч, ажлын шаардлага хангахгүй тухай дүгнэлт гарсан, ХЭГ-ын автомашиныг НХХЯ-нд татан авснаар ТӨХ, Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны зөвшөөрлыг үндэслэн зохих хууль журмын дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, агентлагийн албан хэрэгцээнд Ланд крузер автомашиныг худалдаж авсан юм. ТӨХ-ны шийдвэрээр шинэ агентлагт төрийн өмчийн 7 дугаар байрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн тул ажлын байрны нөхцөл сайжруулах үүднээс олон жил засвар үйлчилгээ хийгдээгүй тус байранд иж бүрэн засвар хийсэн.

Энэхүү автомашин худалдан авсан, байранд засвар хийсэн, техник тоног төхөөрөмжөөр хангасан зэрэг нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэр, баталсан төсвийн хүрээнд шийдвэрлэгдсэн бөгөөд Үндэсний аудитын газрын болон Улсын мэргэжлын хяналтын газрын 2005 оны хяналт шалгалтанд хамарч, баталгаажсан асуудал юм.


3.НХХЯ-ны ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх, үүргээ хэрэгжүүлсэн байдлын талаар

Дотоод хяналт сул, гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн нягтлан бодох бүртгэл хангалтгүй зэргээс шалтгаалж бичиг баримт хуурамчаар үйлдэх, ажлын байрны төлбөрөөс зайлсхийх зэрэг зөрчил 2004 онд 6 удаа, 2006 онд 2 удаа гарсаныг ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албатай хамтран илрүүлж, 2006 оны зөрчлийг арилгаж ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлсэн болно.

Гэтэл шалгалтын явцад мөн нэр бүхий 3 компани хуурамчаар бичиг баримт үйлдэж, ажлын байрын төлбөрөөс зайлсхийсэн тохиолдол илэрсэн байна.

Эдгээр хууль зөрчсөн асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж, буруутай этгээдүүдийг тогтоож, хариуцлага тооцох тул асуудлыг эцэслэн шийдвэрлэгдтэл байгууллага, албан тушаалтныг буруутган шалгалтын акт дүгнэлтэд тусгахгүй байхыг хүсэж байна.



 Д.БАЯРСАЙХАН

Тайлбар 4

Банк, ББСБ-уудад байршуулсан хөрөнгөөс жижиг зээлд олгоогүй үлдэгдэл өссөн, Анод банк 2005 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 500 сая төгрөг авч ашигласан боловч жижиг зээлийн зориулалтаар 4 сая төгрөгийн зээл олгож бусдыг өөрийн үйл ажиллагаанд ашигласан тул жижиг зээлд олгох хөрөнгийг зохих ёсоор зарцуулж байна гэж дүгнэх бололцоогүй байна.

Тайлбар 5

Ажилгүйдлийг бууруулах асуудлыг санхүүгийн хязгаарлагдмал боломжтой ганц агентлагийн үйл ажиллагаатай холбон тайлбарлах нь учир дутагдалтай гэсэн саналыг хүлээн авч аудитын тайланд зохих өөрчлөлт оруулав.

Тайлбар 6

ЗГ-ын 2001 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг зөрчсөн, ХЭДС-гаас зарцуулахаар батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн тул холбогдох шийдвэрийг гаргуулсан гэж зөвтгөх үндэслэлгүй байна.

Тайлбар 7

Хуурамч бичиг баримтаар ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн нь аудитаар илэрсэн тул уг баримтад нэр холбогдсон байгууллага, албан тушаалтныг дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль

тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн нэгтгэл

(сая.төгрөгөөр)

№	Хариуцагч байгууллага	Төлбөр зөрчлийн агуулга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Төлбөр, зөрчлийн дүн
1	ХХҮГ	ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам зөрчиж, 17 дотоодын ТББ-ыг АБТ-өөс чөлөөлсөн	165.2		165.2
2	ХХҮГ	ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам зөрчиж, "СНМ" ХХК-г АБТ-өөс чөлөөлсөн	5.4		5.4
3	ХХҮГ	ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам зөрчиж, "Цайрт минерал" ХХК-г АБТ-өөс чөлөөлсөн	539.6		539.6
4	ХХҮГ	ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам зөрчиж, "Алтандорнод" ХХК-г АБТ-өөс чөлөөлсөн	208		208
5	ХХҮГ	ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам зөрчиж, "Богда холдинг" ХХК-г АБТ-өөс чөлөөлсөн.	41		41
6	ХХҮГ	"Богда холдинг" ХХК АБТ-ийг хураамж төвлөрүүлдэг данс руу андууран шилжүүлсэн	8.7		8.7
7	ХХҮГ	"Жамп" ХХК АБТ дутуу төлсөн	1.3		1.3
8	ХХҮГ	"Икс ди эф" ХХК хуурамч бичиг баримтаар АБТ-өөс зайлсхийсэн	21.6		21.6
9	ХХҮГ	"Лиашинан" ХХК хуурамч бичиг баримтаар АБТ-өөс зайлсхийсэн	10.2		10.2
10	ХХҮГ	"Монголхо-Цэн" ХХК хуурамч бичиг баримтаар АБТ-өөс зайлсхийсэн	12.7		12.7
11	ХХҮГ	АБТ-ийн тооцоог шалгаж тохируулах			
12	ХХҮГ	"Алтандорнод" ХХК-ийн ээлжийн амралт авсан ажилтнуудыг АБТ-өөс чөлөөлснийг хууль журамд нийцүүлэх		838	838
13	"Зуучлагч товчоо" ХХК	Татварын хууль зөрчиж, татвар ногдох орлого нуусан	158		158
		нийт дүн	1171.7	838	2009.7

**Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ явуулах эрхийн
зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж**

№	Байгууллагын нэр	Илгээж буй орон	Хэдэн оноос үйл ажиллагаа явуулж байгаа
1	Заг ХХК	Япон	1998
2	Бридж ХХК	Япон	2002
3	Монгол ньюс ХХК	БНСУ	2002
4	Хонза ХХК	БНЧУ	2001
5	Оюунтүлхүүр сан ТББ	Япон	2001
6	Их хийморь төв ТББ	Япон	2002
7	Зуучлагч товчоо ХХК	Тайвань, БНСУ	2002
8	Ти энд Ди Си ХХК	Япон	2001
9	Кон Арт урлагийн төв	Япон	2003
10	Гэгээлэг трэйд ХХК	Япон	2003
11	Адана ХХК	Япон	2003
12	Будын ХХК	БНУУ	2002
13	Талын болор ХХК	Япон	2005
14	Ариунсэка ХХК	Япон	2005
15	Гурван уул мандал ХХК	БНЧУ	2005
16	Монгол Алтай Индастри ХХК	Япон	2001
17	Монгол-Японы Худалдаа аж үйлдвэрийн нийгэмлэг	Япон	2006
18	Будсүмбэрэл ХХК	Япон	2006
19	Форестер ТББ	Япон	2006
20	Сэлэнгийн хөгжлийн төлөө сан ТББ	Япон	2006
21	Ти Си Ай ХХК	Япон	2006